



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТАД МӨРДӨХ ХУУЛЬ, ЖУРАМ, ЗААВРЫН
ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Улаанбаатар хот
2017 он



АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт.....	1
Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар	Хүснэгтэн болон зурган мэдээллийн жагсаалт.....	2
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, хугацаа, арга зүй.....	3
Б.Алтанзул	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	3-4
Аудитын менежер	Үндсэн мэдээлэл.....	5
Х.Болдбаатар	Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилаагүй байна.....	6-12
Ахлах аудитор	1.1 ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн тооцоололд ашигладаг “Сум хөгжлийн индекс”-ийг шинэчлээгүй байна.....	6-8
Я.Наранцэцэг	1.2 ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.....	8
Аудитор	1.3 ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг бүрэн олгосон байна.....	8-10
Л.Нямтөмөр	1.4 ОНХНС болон улсын төсвөөс олгох шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна.....	11-12
А.Ариунзаяа	Бүлэг 2. ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөвгүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж гүйцэтгэсэн байна.....	13-26
2017 оны 06 дугаар сар	2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй байна.....	13-14
Уг тайланг УАГ-ын вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn	2.2 ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтан гарсан байна.....	15-16
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.	2.3 ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөвгүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.....	16-17
Хаяг:	2.4 Зарим үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.....	17-19
Үндэсний аудитын газар	2.5 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.....	19-21
Засгийн газрын IY байр	2.6 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна.....	22-24
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот 15160 Монгол Улс	2.7 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу бүртгэл тайланд тусгаагүй байна.....	24-26
	Бүлэг 3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна...	27-31
	3.1 ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон дотоод аудитын алба ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.....	27



3.2 ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын дагуу хүргүүлж, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.....	27-28
3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг олон нийтэд хүргээгүй байна.....	28-29
3.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг бусад хууль, тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.....	29-30
3.5 Өмнөх аудитаар өгөгдсөн актын биелэлт 86.4 хувь, албан шаардлагын биелэлт 91.1 хувь, зөвлөмжийн биелэлт 75.5 хувьтай байна	30-31
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....	32
Саналд өгөх тайлбар.....	33
Дүгнэлт	34
Зөвлөмж	35-36
Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал.....	37
Хавсралт 1.....	38
Хавсралт 2.....	39
Хавсралт 3.....	40
Хавсралт 4.....	41
Хавсралт 5.....	42



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БЗД	Баянзүрх дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НАГ	Нийцлийн аудитын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СБД	Сүхбаатар дүүрэг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1	ОНХНС болон улсын төсвийн эх үүсвэрийн төлөвлөлт
ХҮСНЭГТ 2	ОНХНС болон улсын төсвийн орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл, ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг
ХҮСНЭГТ 3	Орон нутгийн хөгжлийн санд 2016 онд төвлөрсөн эх үүсвэр
ХҮСНЭГТ 4	ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл
ХҮСНЭГТ 5	ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагаа

ЗУРАГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1	ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг
ЗУРАГ 2	ОНХС-д орон нутгаас төвлөрүүлсэн орлого
ЗУРАГ 3	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын уурын зуухны барилга
ЗУРАГ 4	Дундговь аймгийн 644.7 сая төгрөгийн өртөгтэй “Өвлийн нарлаг хүлэмж”
ЗУРАГ 5	Архангай аймгийн Цэнхэр сумын 48.9 сая төгрөгийн өртөгтэй “Өвсний фондны хашаа”
ЗУРАГ 6	ОНХС-ийн эх үүсвэр, илэрсэн зөрчлийн харьцаа
ЗУРАГ 7	Аудитаар илэрсэн зөрчил
ЗУРАГ 8	Өмнөх аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт



Аудит хийх үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоолыг үндэслэн ҮАГ-ын 2017 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, нэгтгэсэн дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ болон хугацаа

Аудитад ОНХНС, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хороодыг хамруулж ОНХС-ийн 2016 оны хөрөнгийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, хэрэгжүүлсэн төсөл, арга, хэмжээ, түүний гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг авч үзлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно. Мөн аудитын хүрээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн талаарх иргэдийн мэдээлэл, оролцоог үнэлэх зорилгоор 20 аймаг болон нийслэлийн нийт 21728 иргэнээс санал асуулга авлаа.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актууд болон аудитын стандартуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2012 оны “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- Сангийн сайдын 2016 оны “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 233 дугаар тушаал
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.



Үндсэн мэдээлэл

Монгол Улсын Төсвийн тухай хуульд *“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ”* гэж заасан байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар 2016 оны төсвийн жилээс эхлэн аймаг, нийслэлийн ОНХС-д ОНХНС-аас олгох шилжүүлгээс гадна Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.6¹, 60.2.7²-д заасан шилжүүлгийг улсын төсвөөс олгохоор хуульчилжээ.

ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан *“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”*, Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар батлагдсан *“Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал”*-ыг тус тус мөрдөж байна.

Мөн орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан *“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”*, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан *“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”*-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 131,043.3 сая төгрөгөөр баталсныг Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар 120,267.7 сая төгрөг болгон тодотгосон байна.

Аймаг, нийслэлийн ОНХС-д ОНХНС болон улсын төсвөөс 2016 онд гүйцэтгэлээр 120,267.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, өмнөх оны үлдэгдэл 11,966.4 сая, орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 6,986.6 сая, татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр 11,140.0 сая, хандив тусламжаар 3,814.6 сая нийт 154,175.3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр төвлөрүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, нийслэл, сум, дүүргүүдийн ИТХ 2016 онд нийт 5311 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсанаас гүйцэтгэлээр 80.0 хувь буюу 4,249 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 5.2 хувь буюу 277 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж, 14.8 хувь буюу 785 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

¹ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 30 хувь; /Энэ заалтад 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулж “30 хувь” гэснийг “10 хувь” гэж өөрчилсөн, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос” гэсний өмнө “Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад” гэж нэмэлт оруулсан/

² ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.



БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛААГҮЙ БАЙНА

1.1 ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн тооцоололд ашигладаг “Сум хөгжлийн индекс”-ийг шинэчлээгүй байна

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 131,043.3 сая төгрөгөөр баталсныг эрдэс бүтээгдэхүүний үнийн бууралтаас шалтгаалан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар 120,267.7 сая төгрөг болгон тодотгосон байна.

ОНХНС болон улсын төсвийн эх үүсвэрийн төлөвлөлтийг хүснэгт 1–т үзүүлэв.

Хүснэгт 1. ОНХНС болон улсын төсвийн эх үүсвэрийн төлөвлөлт (сая төгрөг)

	Эх үүсвэр	Батлагдсан	Тодотгол	Зөрүү
ОНХНС-аас олгох	Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	16,127.4	16,141.6	14.2
	Дотоодын НӨАТ-ын орлогын 10 хувь ³	54,800.0	41,800.0	(13,000.0)
	Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь	9,621.2	4,944.9	(4,676.3)
	АМНАТ-ийн орлогын 5 хувь	19,819.6	12,769.6	(7,050.0)
Улсын төсвөөс олгох	АМНАТ-Мега төсөл 30 хувь	15,069.3	29,005.8	13,996.5
	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл 50 хувь	15,605.8	15,605.8	-
Нийт		131,043.3	120,267.7	(10,775.6)

Эх сурвалж: Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хууль, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хууль

Сангийн яам ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлтийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2⁴, 59.3⁵ дахь заалт, ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга гэсэн 4 төрлийн итгэлцүүрт үндэслэн тооцоолсон байна.

Мөн улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох 2 төрлийн шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5⁶, 60.6⁷ дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр,

³ /Энэ заалтад 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулж “10 хувь” гэснийг “5 хувь” гэж өөрчилсөн/

⁴ Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн сангаас энэ хуулийн 59.1.1-59.1.5-д заасан орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна.” /Энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар “59.2.Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна: 59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх; 59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах; 59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.6, 60.2.7-д заасан орлогын шилжүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6, 60.7-д заасан хувь хэмжээгээр хуваарилах.” хэмээн өөрчлөн найруулсан байна./

⁵ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс;
59.3.2.хүн амын тоо;
59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;
59.3.4.орон нутгийн татварын идэвх санаачилга.

⁶ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.6-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.

⁷ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.



ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос ОНХС-д олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ыг баримтлан ашигт малтмал ашигласан болон тусгай зөвшөөрөл олгогдсон талбайд байрших тухайн сум, дүүргийн ОНХС-д олгохоор төлөвлөсөн байна.

Засгийн газрын 2014 оны 242 дугаар тогтоолоор "Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал"-ыг баталсан бөгөөд сумын хөгжлийн 2013 оны индексийг 2014 оны 4 дүгээр улиралд багтаан зарлаж, цаашид 2 жилд 1 удаа тооцож байхыг ЭЗХЯ-нд даалгасан ч тухайн яам татан буугдаж, уг индексийг 2016 онд шинэчлэн тооцож зарлаагүй байна.

Энэ нь нэр бүхий аймгууд Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын 9.4⁸-т заасны дагуу үлдсэн 3 төрлийн үзүүлэлтэд үндэслэн, бусад аймгууд 2013 оны хөгжлийн индексийг ашиглан төлөвлөлтийг хийхэд хүргэжээ. Тухайлбал:

- Архангай, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Хэнтий аймгууд Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын 9.4-т "Энэ аргачлалын 3.2.1-д заасан орон нутгийн хөгжлийн индексийг сум, дүүргийн түвшинд үнэн зөв, бодитой байдлаар гаргах боломжтой болох хүртэлх хугацаанд уг индексэд харгалзах 25 хувийг аргачлалын 3.2.2-3.2.4-т заасан үзүүлэлтүүдэд тэнцүү хуваарилах байдлаар орлуулан хэрэглэж болно" гэж заасны дагуу хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга гэсэн 3 төрлийн үзүүлэлтийг ашиглан төлөвлөсөн;
- Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Төв, Ховд, Хөвсгөл аймгууд хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга болон шинэчлэн зарлаагүй орон нутгийн хөгжлийн индексийг ашиглан төлөвлөсөн;
- Булган аймаг хөгжлийн индекс батлагдах хүртэлх хугацаанд орон нутгийн хөгжлийн индексд ногдох хэсгийг үлдэх 3 итгэлцүүрт тэнцүү хэмжээгээр хуваарилан ашиглаж байхаар заасны дагуу тооцоолоход сумдад 68.1 сая төгрөг дутуу хуваарилсан;
- Мөн Нийслэлийн ЗДТГ-ын СТСХ нь нийслэлийн ИТХ-ын 2012 оны 79 дүгээр тогтоолыг үндэслэн хүн амын тоонд 50 хувиар, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнд 25 хувиар, орон нутгийн татварын идэвхи санаачлагад 25 хувиар тооцож төлөвлөсөн нь ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын 3.2.1⁹, 9.4 дэх заалтыг зөрчжээ.

Мөн Дархан-Уул, Сүхбаатар, Төв, Өмнөговь, Дундговь, Увс аймгаас бусад аймаг, нийслэл Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5¹⁰, 60.6¹¹ дахь заалтыг зөрчин ОНХНС болон улсын төсвөөс шилжүүлэх орлогыг зөвхөн ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын дагуу төлөвлөөгүй байна.

⁸ Энэ аргачлалын 3.2.1-д заасан орон нутгийн хөгжлийн индексийг сум, дүүргийн түвшинд үнэн зөв, бодитой байдлаар гаргах боломжтой болох хүртэлх хугацаанд уг индексэд харгалзах 25 хувийг аргачлалын 3.2.2-3.2.4-т заасан үзүүлэлтүүдэд тэнцүү хуваарилах байдлаар орлуулан хэрэглэж болно

⁹ 3.2.1. орон нутгийн хөгжлийн индекс-харгалзах хувийн жин 25 хувь;

¹⁰ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.6-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.

¹¹ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.



Иймд ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөж, хуваарилахад Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5¹², 60.6¹³ дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос ОНХС-д олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

1.2 ОНХС-ийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2¹⁴ дахь заалтад ОНХС-ийн эх үүсвэр нь 6 төрлийн орлогоос бүрдэхээр заасан ч нэр бүхий аймаг болон нийслэл ОНХС болон улсын төсвөөс хуваарилагдсан шилжүүлгийн орлогоос бусад нэр төрлийн эх үүсвэрийг төлөвлөөгүй нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1¹⁵, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.2.2¹⁶, 2.2.3¹⁷, 2.2.4¹⁸ дэх заалтыг биелүүлээгүй байна. Тухайлбал:

- Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Завхан аймаг орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг хасч үлдэх хэсэг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр болон дотоод гадаадын хандив, тусламжийн эх үүсвэрийг төлөвлөөгүй;
- Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймаг орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг хасч үлдэх хэсэг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэрийг төлөвлөөгүй;
- Булган, Өмнөговь аймаг орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг хасч үлдэх хэсэг болон дотоод гадаадын хандив, тусламжийн эх үүсвэрийг төлөвлөөгүй;
- Говьсүмбэр, Хэнтий, Хөвсгөл аймаг дотоод гадаадын хандив, тусламжийн эх үүсвэрийг төлөвлөөгүй;
- Дорнод, Дундговь, Орхон, Увс аймаг татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэрийг төлөвлөөгүй;
- Нийслэлийн 2016 оны үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагатай тэнцэх хэсгээс бага, хандив тусламжийн орлогыг төлөвлөх боломжгүй байснаас уг эх үүсвэрүүдийг төлөвлөөгүй, мөн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэнээр бүрдэх 15,962.9 сая төгрөгийн орлогыг ОНХС-ийн эх үүсвэрт төлөвлөөгүй байна.

Дээрх аймаг, нийслэлийн удирдлага нь ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлөөр төлөвлөх, бүрдүүлэх талаар санаачлагагүй ажилласан байна

1.3 ОНХС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг бүрэн олгосон байна

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар аймаг, нийслэлийн ОНХС-д дотоодын НӨАТ-ын орлогоос 41,800.0 сая, АМНАТ-ын орлогоос 12,769.6 сая, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 4,944.9 сая, төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 16,141.6 сая төгрөг, мөн Төсвийн тухай

¹² Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.6-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.

¹³ Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.7-д заасан орлогын 50-аас доошгүй хувийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.

¹⁴ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

¹⁵ төсвийн зарчмыг мөрдлөг болгох

¹⁶ Төсвийн тухай хуулийн 59.2-т заасан хөрөнгө

¹⁷ Төсвийн тухай хуулийн 56.2-т заасан орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг

¹⁸ татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр



хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.6-д заасан орлогын шилжүүлгээс 29,005.8 сая, 60.2.7-д заасан орлогын шилжүүлгээс 15,605.8 сая нийт 120,267.7 сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр дотоодын НӨАТ, АМНАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмал хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлого төлөвлөгөөнөөс давж биелэсэн байна.

ОНХНС болон улсын төсвийн орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл, ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийг хүснэгт 2-оор үзүүлэв.

Хүснэгт 2. ОНХНС болон улсын төсвийн орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл, ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг (сая төгрөг)

Эх үүсвэрийн нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг
Дотоодын НӨАТ-ын орлогын 10 хувь	41,800.0	45,887.84	46,624.0
АМНАТ-ын орлогын 5 хувь	12,769.6	14,435.70	14,435.7
Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь	4,944.9	6,230.30	6,230.3
Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	16,141.6	16,141.60	16,141.6
АМНАТ-Мега төсөл 30 хувь	29,005.8	28,597.19	24,714.7
Ашигт малтмал хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл 50 хувь	15,605.8	17,404.84	12,121.4
НИЙТ	120,267.7	128,697.47	120,267.7

Эх сурвалж: Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтэс

Хэдийгээр ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д 120,267.7 сая төгрөг буюу орлогын шилжүүлгийг бүрэн олгосон боловч дотоодын НӨАТ-ын орлогоос 46,624.0 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1¹⁹ дэх заалттай нийцэхгүй байна.

Аймаг, нийслэлийн ОНХС-д 2016 онд нийт 154,175.5 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн бөгөөд 8.0 хувь буюу 11,966.4 сая төгрөг нь өмнөх оны үлдэгдэл, 78.0 хувь буюу 120,267.7 сая төгрөг нь ОНХНС болон улсын төсвийн шилжүүлэг, 5.0 хувь буюу 6,986.6 сая төгрөг нь үндсэн тэнцлийн ашиг, 7.0 хувь буюу 11,140.0 сая төгрөг нь татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр, 2.0 хувь буюу 3,814.6 сая төгрөг нь дотоод, гадаадын хандив тусламжийн эх үүсвэрээс бүрдсэн байна. /Хавсралт 1/

Орон нутгийн хөгжлийн санд 2016 онд төвлөрсөн эх үүсвэрийг хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Орон нутгийн хөгжлийн санд 2016 онд төвлөрсөн эх үүсвэр (сая төгрөг)

Эх үүсвэр	Дүн	Хувийн жин
Өмнөх оны үлдэгдэл	11,966.4	8 хувь
ОНХНС болон улсын төсвөөс олгох 2 төрлийн орлогын шилжүүлэг	120,267.7	78 хувь
Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	6,986.6	5 хувь
Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	11,140.0	7 хувь
Хандив, тусламж болон бусад	3,814.6	2 хувь
НИЙТ	154,175.5	100 хувь

¹⁹ 59.1.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

59.1.1.импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 10 хувь; /Энэ заалтад 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулж “10 хувь” гэснийг “5 хувь” гэж өөрчилсөн/



Эх сурвалж: Орон нутаг дахь төрийн аудитын газрын орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан


Зарим аймаг, нийслэлийн удирдлагууд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1²⁰, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1²¹ дэх заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгийн бусад эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бүрдүүлэх талаар санаачлагагүй ажилласан байна. Тухайлбал:

- Нийслэл хуульд заасан 6 төрлийн эх үүсвэрээс 3 төрлийн эх үүсвэрийг бүрдүүлсэн, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрээс орох орлогыг бүрдүүлээгүй;
- Говь-Алтай аймагт хайгуул лицензийн төлбөрийн орлогоос 130.0 сая төгрөгийг оруулахаар тооцож төлөвлөсөн боловч хэрэгжээгүй;
- Өвөрхангай аймаг төсвийн үндсэн тэнцлийн ашиг, хандив, тусламжийн орлого болон бусад эх үүсвэрийг төлөвлөж бүрдүүлээгүй байна.


ОНХС-д 2016 онд төвлөрсөн эх үүсвэрийг 2015 онтой харьцуулахад орлогын шилжүүлэг 14,283.1 сая, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болсон нэмэгдэл эх үүсвэр 805.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн тэнцлийн ашгаас төвлөрүүлсэн орлого 1,169.1 сая төгрөгөөр, хандив тусламж болон бусад эх үүсвэрийн орлого 4,483.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ОНХС-д олгосон орлогын шилжүүлэг, орон нутгаас төвлөрүүлсэн орлогыг зургаар үзүүлэв.

Зураг 1. ОНХС болон улсын төсвөөс аймаг, олгосон орлогын шилжүүлэг (тэрбум төгрөг)



Зураг 2. ОНХС-д орон нутгаас төвлөрүүлсэн орлого (тэрбум төгрөг)



Эх сурвалж: УАГ-ын орон нутгийн хөгжлийн сангийн 2013-2015 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан, орон нутаг дахь төрийн аудитын газрын орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан

²⁰ Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

²¹ Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар тооцож төлөвлөнө



1.4 ОНХНС болон улсын төсвөөс олгох шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна

Сангийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 319 дүгээр тушаалаар аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг баталсан байна.

ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д 1 дүгээр улиралд 4,964.4 сая, 2 дугаар улиралд 7,654.4 сая, нийт 12,618.8 сая төгрөгийг батлагдсан хуваариас дутуу, 3 дугаар улиралд 11,648.1 сая, 4 дүгээр улиралд 1,148.5 сая, нийт 12,796.6 сая төгрөгийг батлагдсан хуваариас илүү шилжүүлэн 177.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3²² дахь заалтыг зөрчсөн байна.

ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4. ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөг)

Улирал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	14,402.7	9,438.3	(4,964.4)
II	48,801.4	41,147.1	(7,654.4)
III	23,727.0	35,375.1	11,648.1
IV	33,336.6	34,485.1	1,148.5
Нийт	120,267.7	120,445.5	177.8

Эх сурвалж: Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтэс

ОНХНС болон улсын төсвөөс олгох шилжүүлгийг аймаг, нийслэлийн ОНХС-д батлагдсан хуваарийн дагуу олгоогүй нь ОНХС-ийн эх үүсвэрийг бүрэн ашиглах, төлөвлөсөн төсөл, арга хэмжээг тухайн онд хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх, цаг хугацаа алдах эрсдэлийг үүсгэсэн байна.

Мөн зарим аймаг ОНХНС болон улсын төсвөөс шилжүүлэх орлогыг зөвхөн ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын дагуу тооцоолж олгохдоо Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн сангаас энэ хуулийн 59.1.1-59.1.5-д заасан орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэж заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

- Баян-Өлгий аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 50.0 хувийг сумдад, 50.0 хувийг аймагт;
- Булган аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 58.0 хувийг сумдад, 42.0 хувийг аймагт;
- Говь-Алтай аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 54.0 хувийг сумдад, 46.0 хувийг аймагт;
- Дархан-Уул аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 48.0 хувийг сумдад, 52.0 хувийг аймагт;
- Дорноговь аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 51.0 хувийг сумдад, 49.0 хувийг аймагт;
- Дорнод аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 55.0 хувийг сумдад, 45.0 хувийг аймагт;
- Сэлэнгэ аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 54.0 хувийг сумдад, 46.0 хувийг аймагт;
- Завхан аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 55.0 хувийг сумдад, 45.0 хувийг аймагт;
- Увс аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 51.0 хувийг сумдад, 49.0 хувийг аймагт;

²² Төсвийн сар, улирлын хуваарийг төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг үндэслэн энэ хуулийн 11 дүгээр зүйл, 65.1, 66.1-д заасан эрх бүхий этгээд баталж, мөрдүүлнэ.



- Ховд аймаг ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн 53.0 хувийг сумдад, 47.0 хувийг аймагт тус тус хуваарилсан;
- Мөн Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд аргачлалийн дагуу 379.9 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хийгдэх ёстой байхад бусад сумдад олгох шилжүүлгээс хасч, тус сум дээр нэмж тодотгон, 858.3 сая төгрөгөөр баталсан байна.



БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ЗУРАГ ТӨСӨВГҮЙ, ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ ХИЙГДЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙНА

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд нийт 164,559.1 сая төгрөгийн өртөгтэй 5311 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас 80.0 хувь буюу 4,249 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 5.2 хувь буюу 277 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн, 14.8 хувь буюу 785 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Хавсралт 2/

2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй байна

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлд тухайн шатны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч урьдчилсан жагсаалт бэлтгэн олон нийтээр хэлэлцүүлж, нийтийн эрх ашигт нийцсэн нэгдсэн жагсаалтыг ИТХ-д өргөн мэдүүлэхээр заасан.

Мөн дээрх журмын 6.3.4²³, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 2.2²⁴, 4.1²⁵ дэх заалтуудад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр, УИХ, Засгийн газар болон тухайн орон нутгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги, орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байхаар тусгасан байна.

Аймаг, нийслэлийн удирдлага ОНХС-ийн эх үүсвэрээр 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн дор дурдсанаас бусад хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна. Тухайлбал:

- Нийслэлд тухайн дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгаагдаагүй 31 ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн;
- Булган аймгийн Орхон, Дашинчилэн, Гурванбулаг, Сэлэнгэ сумд хөгжлийн бодлоготой уялдуулсан урьдчилсан саналын жагсаалт бэлтгээгүй;
- Увс аймгийн хэмжээнд 34 төсөл, арга хэмжээ тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй;
- Хөвсгөл аймгийн нийт сумд урьдчилсан жагсаалтыг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй;
- Сэлэнгэ аймгийн Сант сумын ажлын хэсэг иргэдээс ирсэн саналыг сумын хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийгээгүй.

Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн, саналын урьдчилсан жагсаалт бэлтгээгүй дээрх аймаг, нийслэлийн удирдлага Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар

²³ орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх;

²⁴ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь УИХ, ЗГ болон тухайн орон нутгаас хөгжлийн талаар баримталж байгаа бодлого стратеги, түүнтэй холбоотой бусад бичиг баримттай уялдсан байна.

²⁵ ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр болон тухайн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байх



батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.5²⁶, 5.7²⁷ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ИНХ-аар хэлэлцүүлээгүй, хэлэлцүүлсэн боловч хуралд оролцогчдийн ирцийг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, тухайн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн нийт өртөг зэрэг үзүүлэлтүүдийг тооцоолоогүй байна. Тухайлбал:

- Өмнөговь аймгийн Булган, Мандал-Овоо, Цогтцэций, Ханхонгор, Даланзадгад сумд багийн ИНХ-ын тэмдэглэлийг батлагдсан маягтын дагуу хөтлөөгүй;
- Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Баян-Овоо, Мөрөн, Батноров, Норовлин, Дадал, Биндэр, Баянхутаг, Бор-Өндөр, Өмнөдэлгэр, Галшар, Баян-Адрага, Дэлгэрхаан, Батширээт сумдын ИТХ нь төсөл арга хэмжээг батлахдаа Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тогтоолоор баталсан загварыг мөрдөөгүй;
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3, Сант сумын 1 дүгээр баг ИНХ-ыг зохион байгуулаагүй, Баруунбүрэн, Ерөө, Мандал, Цагааннуур, Сайхан сумдын зарим баг хурлын ирцийг бүртгэж, гарын үсэг зуруулж, баталгаажуулаагүй, Ерөө, Цагааннуур сумын зарим багийн ИНХ нь хурлын тэмдэглэл хөтлөөгүй;
- Орхон аймгийн Жаргалант сумын нийт багууд ИНХ-ыг 6 дугаар сард, Баян-Өндөр сум 10 дугаар сард тус тус зохион байгуулсан;
- Дорноговь аймгийн Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумд багийн ИНХ-ыг 6-10 дугаар саруудад зохион байгуулсан, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх зэрэг үзүүлэлтүүдийг тооцоолоогүй зөрчил багуудад нийтлэг;
- Хөвсгөл аймгийн хэмжээнд ажлын баримтуудыг архивын нэгж болгоогүй, Алаг-Эрдэнэ, Ханх, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр сумд санал асуулгын хуудасгүй;
- Нийслэлийн БХД он дамжин хэрэгжих 404.0 сая төгрөгийн ажлыг төсөл, арга хэмжээ бүрээр бус нийт дүнгээр нь баталсан, СХД төсөл, арга хэмжээний жагсаалтад тухайн төсөл, арга хэмжээний хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, тухайн жилийн санхүүжилтийн дүнг тусгаагүй, Багануур дүүрэг 2,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2016-2017 онд хэрэгжих бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын ажлын 2016 онд санхүүжүүлэх дүнг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилахгүйгээр баталсан байна.

Дээр дурьдсан зөрчлийг орон нутгийн удирдлага гаргасан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4²⁸, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.1.1²⁹, 12.2.1.6³⁰, 12.2.1.в³¹, 12.2.2³² дахь заалтыг зөрчсөн байна.

²⁶ ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тухайн шатны ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэхдээ тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар үндэслэл иргэдийн хурлын санал тэдгээрийг тусгасан байдал гэсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана.

²⁷ Баг хорооны Засаг дарга ИНХ-д иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, харъяа сум, дүүргийн ЗД-аас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдуулсан төслийн санал болон хурлын явцад иргэдээс гарсан саналыг нэг бүрчлэн хэлэлцүүлнэ.

²⁸ төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах

²⁹ аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна;

³⁰ Саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтыг ашиглах ба маягтыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ.

³¹ Энэ журмын 12.2.1.а-д заасан хэлбэрээр санал асуулгыг явуулахдаа, жил бүрийн 2 дугаар улирлын эхний 30 өдөрт багтаан санал авна

³² баг, хорооны Засаг дарга холбогдох маягтын дагуу тухайн баг хорооны иргэдийн ирүүлсэн саналыг багийн ИНХ-д хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг бэлтгэхдээ: 12.2.2.а/ хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх; 12.2.2.б/ хэдэн хүн ашиг хүртэх; 12.2.2.в/ сум, дүүргийн иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх; 12.2.2.г/ төслийн нийт өртөг зэргийг тусгасан байна.



2.2 ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил давтан гарсан байна

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д “Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна”, 63.2-т “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ дээр гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно” гэж заасан байна.

Гэтэл нэр бүхий аймаг, нийслэлийн удирдлага иргэдийн саналаар дэмжигдээгүй, санал авч эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4³³, 60.3.6³⁴, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.1³⁵, 6.3.5³⁶, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.2³⁷ дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Баян-Өлгий аймгийн Булган, Ногооннуур сум болон Цагааннуур тосгонд нийт 184.5 сая төгрөгийн өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээ;
- Булган аймгийн Дашинчилэн сумын 30.0 сая төгрөгийн ажил, Булган сумын 58.1 сая төгрөгийн 7 ажил, Гурванбулаг сумын 22.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 ажил;
- Говь-Алтай аймгийн 271.1 сая төгрөгийн 2 багц төсөл арга хэмжээ, мөн Алтай сумын 23.7 сая төгрөгийн өртөг бүхий 3 арга хэмжээ, Бигэр сумын 33.0 сая төгрөгийн өртөг бүхий 3 арга хэмжээ, Бугат сумын 20.0 сая төгрөгийн арга хэмжээ, Цээл сумын 76.6 сая төгрөгийн 5 арга хэмжээ, Шарга сумын 20.0 сая төгрөгийн арга хэмжээ, Эрдэнэ сумын ИТХ-аас 82.3 сая төгрөгийн 4 арга хэмжээ зэрэг нийт 303.6 сая төгрөгийн өртөгтэй 30 төсөл, арга хэмжээ;
- Дорноговь аймгийн Хөвсгөл сумын 50.0 сая төгрөгийн тохижилтын ажил, Хатанбулаг сумын 34.8 сая төгрөгийн хог зөөврийн машин, Эргэл багийн тэжээлийн агуулахын 20.0 сая төгрөгийн барилга, Мандах сумын 42.6 сая төгрөгийн эм эргэлтийн сангийн барилгын ажил, Соёлын төвийн 30.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж;
- Дундговь аймгийн “Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 20.0 сая, “Барилгын материалын чанарт тавих лабораторын хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр”-ийн 35.0 сая, Өлзийт сум “Хууль сурталчилах хөтөлбөр, нийгмийн хүрээнд иргэдийн дунд зохион байгуулагдах хөтөлбөр”, “Иргэд малчид орон нутгийн удирдлагын хамтын ажиллагаа хөтөлбөр”-ийн 15.2 сая зэрэг нийт 165.6 сая төгрөгийн өртөгтэй 21 төсөл, арга хэмжээ;
- Орхон аймгийн түрээсийн орон сууц худалдан авах 1,241.4 сая төгрөгийн ажил, Даваат багийн 1,196.2 сая төгрөгийн өртөг бүхий сургуулийн барилгын ажил, 246.9 сая төгрөг бүхий зураг төсвийн 11 ажил;
- Хэнтий аймгийн 80.0 сая төгрөгийн 2 арга хэмжээ, Бор-Өндөр сумын 184.8 сая төгрөгийн 16 арга хэмжээ, Хэрлэн сумын 130.7 сая төгрөгийн 9 арга хэмжээ зэрэг нийт 519.4 сая төгрөгийн 45 төсөл, арга хэмжээ;
- Хөвсгөл аймгийн 51.0 сая төгрөгийн өртөг бүхий сургууль, цэцэрлэгийг нэгдсэн халаалтад холбох ажил, Цагаан-Үүр сумын хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн 22.0 сая төгрөг зэрэг нийт 140.6 сая төгрөгийн өртөг бүхий 35 төсөл, арга хэмжээ;
- Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын 25.0 сая төгрөгийн өртөг бүхий ёслол хүндэтгэлийн өргөө;
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 114.1 сая төгрөгийн өртөгтэй хөл бөмбөгийн талбай, Сүхбаатар сумын 85.2 сая төгрөгийн өртөг бүхий байрны засвар, цэнгэлдэх хүрээлэнгийн талбайн 80.0 сая төгрөгийн өртөг бүхий ажил зэрэг нийт 725.4 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ;
- Нийслэлийн БЗД 622.3 сая төгрөгийн өртөгтэй 7 арга хэмжээ, СХД 76.8 сая төгрөгийн өртөгтэй 5 арга хэмжээ, ХУД 13.9 сая төгрөгийн өртөгтэй 2 арга хэмжээ, Налайх дүүрэг 185 сая төгрөгийн өртөгтэй 7 арга хэмжээ, Багануур дүүрэг 88.3 сая төгрөгийн өртөгтэй 4 арга хэмжээ.

³³ нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;

³⁴ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

³⁵ Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримтлах

³⁶ Иргэдийн оролцоог хангасан байх

³⁷ Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх



ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд иргэдийн саналаар дэмжигдээгүй нийт 4,997.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн зөрчилд 3,497.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 1,500.0 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын явцад иргэдээс авсан санал асуулгаар “ОНХС-ийн хөрөнгөөр ямар төсөл, арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас Танай өрхөд ирж байсан уу?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 67.6 хувь буюу 14699 иргэн “саналын хуудас ирдэггүй” гэсэн хариултыг, “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх асуудлыг хэлэлцэх баг, хорооны ИНХ-д та оролцож байсан уу?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 76.0 хувь буюу 16498 иргэн “хааяа” болон “огт үгүй” гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Энэ нь Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.1³⁸ дэх заалтын хэрэгжилт болон баг, хорооны ИНХ-д оролцох иргэдийн оролцоо хангалтгүй байгааг харуулж байна.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөвгүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2³⁹, 29 дүгээр зүйлийн 29.4⁴⁰, Сангийн сайдын 2014 оны 43 тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7⁴¹, 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3⁴² дахь заалтуудыг зөрчин зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

- Нийслэлийн ХУД-ийн 46 дугаар цэцэрлэгийг буулгаж шинээр барих 1,900.0 сая төгрөгийн өртөгтэй ажил;
- Булган аймгийн Рашаант сумын Тарны гүүрийн 20.0 сая төгрөгийн трансформатор, 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий камержуулалтын ажил;
- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЦДАШ, гэрэлтүүлгийн 89.8 сая төгрөгийн ажил, Сүлд багийн 246.3 сая төгрөгийн тохижилтын ажил, хүндэтгэлийн хаалганы 35.0 сая төгрөгийн тохижилтын ажил, Хөвсгөл сумын ЦДАШ-ын өргөтгөл, багийн төвийн цахилгаанжуулалтын 42.5 сая төгрөгийн ажил, худгийн тоног төхөөрөмж, хүндэтгэлийн өргөөний тохижилт, эмнэлэгийн амрах байрны 61.5 сая төгрөгийн ажил;
- Дорнод аймагт өрхийн тариалан эрхлэлтийг дэмжих, дэд бүтэц татах 50.0 сая төгрөгийн ажил, “Сургуулийн бүс”, “Цэцэрлэгийн бүс” төсөл хэрэгжүүлэх 150.0 сая төгрөгийн ажил, “Илч” хорооллын 100.0 сая төгрөгийн өртөг бүхий гудамжны тохижилтын ажил;
- Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын “Нэг цэгийн үйлчилгээний байрны халаалтын систем шинэчлэх” 10.6 сая төгрөгийн ажил;

³⁸ баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна;

³⁹ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;

⁴⁰ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁴¹ Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

⁴² хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх



- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 5-р багийн 79.9 сая төгрөгийн халуун ус барих ажил, Хүрмэн сумын сургуулийн 56.7 сая төгрөгийн халаалтын засвар, Мандал-Овоо сумын 98.8 сая төгрөгийн соёл спортын төвийн барилгын их засвар, 129.6 сая төгрөгийн ахуйн үйлчилгээний төвийн барилга, Ханхонгор сумын 189.5 сая төгрөгийн сургуулийн барилгын засвар, Ханхонгор, Цогт-Овоо, Цогтцэций, Номгон, Баян-Овоо, Ханбогд, Манлай сумдын нутаг дэвсгэрт инженерийн хийцтэй 14 худаг шинээр гаргах 277.0 сая төгрөгийн ажил;
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын 61.4 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил, 63.7 сая төгрөгийн камержуулалтын ажил;
- Хөвсгөл аймгийн ОНХС-өөр хийгдсэн Гурван-эрдэнэ ЕБС, Мөрөнжин 11 дүгээр цэцэрлэгийг нэгдсэн халаалтад холбох 51.0 сая төгрөгийн ажил;
- Хэнтий аймгийн Баянхутаг, Бор-Өндөр, Баянмөнх, Дадал, Хэрлэн, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батноров, Баян-Адрага, Батширээт зэрэг 11 сумдад нийт 561.2 сая төгрөгийн 29 төсөл, арга хэмжээ.

Аудитаар "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангаагүй нийт 4,185.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчил гаргасныг илрүүлж аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 422.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 13 албан шаардлага, 3,762.4 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

2.4 Зарим үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна

ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4169 төсөл, арга хэмжээний хүрээнд 4305 бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 7.4 хувь буюу 318 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 73.1 хувь буюу 3146 ажлыг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 0.4 хувь буюу 18 ажлыг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмаар, 4.6 хувь буюу 197 ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар, 14.5 хувь буюу 626 ажлыг шууд худалдан авсан байна. /Хавсралт 3/

ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааны тоон мэдээллийг хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 5. ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагаа (тоогоор)

Худалдан авах ажиллагааны журам								
Шинэ оны ажил	Нийт худалдан авах ажиллагаа	НТШ-ын журам	Тендер шалгаруулалтын онцгой журам			Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам	ОНО-той худалдан авах ажиллагааны журам	Шууд худалдан авалт
			ХТШ	Харьцуулалтын арга	Гэрээ шууд байгуулах			
4,169	4305	318	17	899	2,230	18	197	626

Эх сурвалж: Орон нутаг дахь төрийн аудитын газрын орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон зарим үнэлгээний хороо, ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахдаа



ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1⁴³, 7.2⁴⁴, 8 дугаар зүйлийн 8.5⁴⁵, 14 дүгээр зүйлийн 14.1.5⁴⁶, 26 дугаар зүйлийн 26.4⁴⁷, 29 дүгээр зүйлийн 29.1⁴⁸, 29.2⁴⁹ 30 дугаар зүйлийн 30.1.3⁵⁰, 33 дугаар зүйлийн 33.2.1⁵¹, 33.3⁵², 47 дугаар зүйлийн 47.4⁵³, 47.6⁵⁴, 47.8⁵⁵, 49 дүгээр зүйлийн 49.1⁵⁶, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4⁵⁷ дэх заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Архангай аймгийн Өлзийт сум 223.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цэвэр усны инженерийн шугам сүлжээ, даралтат цамхагийн ажил”-ын худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар гүйцэтгэсэн, уг ажлыг 250.0 сая төгрөгөөр хийхээр үнийн санал ирүүлсэн Долоон бар ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмжийг Засаг даргад хүргүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.2, 30.1.3 дахь заалтыг зөрчсөн;
- Говь-Алтай аймгийн Алтай, Бигэр, Дэлгэр, Халиун, Цогт, Цээл сумд төсөвт өртгийг хуваан шууд гэрээ байгуулсан, 10.0 сая төгрөгөөс дээш өртөгтэй 290.3 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулан худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1, 8.5, 47.4 дэх заалтуудыг зөрчсөн;
- Дорнод аймгийн Хөлөнбуйр сум 65.0 сая төгрөгийн, Цагаан-Овоо сум 79.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тракторыг тус тус шууд худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1 дэх заалтыг зөрчсөн;
- Дундговь аймгийн Луус, Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Дэрэн сумд 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худаг гаргах ажлыг шууд худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1 дэх заалтыг, Дэрэн суманд 49.9 сая төгрөгийн өртөгтэй ажлын төсөв зохиогч нь гүйцэтгэгчид зөвлөхөөр ажиллаж буй тендерийг шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14.1 дэх заалтыг тус тус зөрчсөн;
- Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын 64.8 сая төгрөгийн өртөгтэй эмийн сангийн барилгын ажил, 30.8 сая төгрөгийн өртөгтэй чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил, Хүрмэн сумын удирдлагын ордны гадна талбайн өргөтгөлийн 35.0 сая төгрөгийн өртөгтэй ажил нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29.2 дахь заалтыг, Баяндалай сумын 10.0 сая төгрөгийн өртөгтэй худаг засварлах ажил, Гурвантэс сумын сургуулийн дотуур байрыг тоног төхөөрөмжөөр хангах 32.5 сая төгрөгийн өртөгтэй ажил, Номгон сумын анализатор аппарат нийлүүлэх 20.0 сая төгрөгийн өртөгтэй ажил нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33.3 дахь заалтыг тус тус зөрчсөн;
- Ховд аймгийн 40.0 сая төгрөгийн өртөгтэй шинэ суурьшлын бүсэд ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил, 49.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгт хүрээлэнгийн зураг

⁴³ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна...

⁴⁴ Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.

⁴⁵ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

⁴⁶ тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

⁴⁷ Энэ хуулийн 26.2-т заасан этгээд, захиалагч байгууллагын төлөөлөгч энэ зүйлийн 26.3-т заасан тэмдэглэлд гарын үсэг зурна.

⁴⁸ Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

⁴⁹ гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах

⁵⁰ шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн

⁵¹ техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх;

⁵² Энэ хуулийн 33.2.1-д заасан үнийн санал ирүүлэх хугацааг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно.

⁵³ Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутаг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

⁵⁴ Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

⁵⁵ Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна.

⁵⁶ Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.

⁵⁷ “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”



төсвийн ажлуудыг “UDC GROUP” ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1 дэх заалтыг зөрчсөн;

- Хэнтий аймгийн Өмнөдэлээр сум 40.0 сая төгрөгийн малжуулах төслийг шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1 дэх заалтыг зөрчсөн;
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 34.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоглоомын талбай барих, засварлах ажил, Орхон сумын 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй наадмын талбай барих ажлуудын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгохдоо эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг албан ёсоор мэдэгдээгүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33.2.1 дэх заалтыг, тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан Самосон ХХК-ийг сонгон шалгаруулсан, Сүхбаатар сум 76.4 сая төгрөгийн гэрэлтүүлгийн ажлын төсвийг 2 хувааж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, Мандал сумын зам талбайг сайжруулах 79.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчээр тусгай зөвшөөрөлгүй Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ-ыг сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1, 8.5 дахь заалтуудыг зөрчсөн;
- Нийслэлийн СБД, СХД, ХУД, Налайх дүүргийн нийт 267.7 сая төгрөгийн өртөгтэй төсөл, арга хэмжээний үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлийн шаардлага хангаагүй 13 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан, үнэлгээний хорооны ирц бүрдээгүй байхад БЗД, СХД-ийн 438.7 сая төгрөгийн өртөгтэй 5 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээг хийсэн, Чингэлтэй дүүргийн 463.7 сая төгрөгийн өртөгтэй 7 ажлын үнэлгээний хорооны 4 гишүүн худалдан авах чиглэлээр мэргэшээгүй зэрэг нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29.1, 47.6, 49.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 8 дугаар зүйлийн 8.5, 14 дүгээр зүйлийн 14.1.5, 26 дугаар зүйлийн 26.4, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.3, 33 дугаар зүйлийн 33.2.1, 33.3, 47 дугаар зүйлийн 47.4, 47.6, 47.8, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх заалтыг зөрчсөн 2,040.4 сая төгрөгийн зөрчил гаргасныг илрүүлж 45.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 1,475.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 36 албан шаардлага, 519.7 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

2.5 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл⁵⁸, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7⁵⁹-д аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлсон байна.

Нэр бүхий аймаг, сум болон нийслэлийн зарим дүүргийн удирдлага ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлсэн, сангийн хөрөнгийг урсгал зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1⁶⁰, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.3⁶¹, 4.4⁶², 4.5⁶³, 4.6⁶⁴ дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Баянхонгор аймгийн Өлзийт сумын 3-р багийн төв барихад 30.0 сая төгрөг зарцуулсан;
- Булган аймгийн Могод, Орхон, Рашаант, Хялганат, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум 28.4 сая төгрөгөөр цагдаагийн торгуулийн машин худалдан авсан, Гурванбулаг, Баян-Агт сум олон нийтийн цагдааг 9.9 сая төгрөгөөр цалинжуулсан;

⁵⁸ Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг

⁵⁹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүд

⁶⁰ орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.

⁶¹ Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх

⁶² “Аймаг, нийслэл, сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх”

⁶³ Орон нутгийн төсвийн бус байгууллагад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх

⁶⁴ ОНХС-ийн хөрөнгийн буцалтгүй тусламж, дэмжлэгт зарцуулахгүй байх



- Говь-Алтай аймгийн нийт сумд 57 төсөл, арга хэмжээнд 123.7 сая төгрөг, аймгийн ОНХС-аас боловсролын салбарын хөтөлбөрийн хүрээнд 203.2 сая төгрөг, Баруун бүсийн тариалан хөгжүүлэх ажлын хүрээнд 57.9 сая төгрөг, Бугат, Дариг суманд дэмжлэг 29.3 сая төгрөг, үйлдвэр байгуулах дэмжлэг 200.0 сая төгрөг зэрэг нийт 598.5 сая төгрөгийг зарцуулсан;
- Дархан-Уул аймгийн ОНХС-ийн хөрөнгөөс бүжигчдийн улсын уралдаан зохион байгуулахад 25.0 сая төгрөг зарцуулсан;
- Дорноговь аймаг ОНХС-ийн хөрөнгөөс Мандах суманд 42.6 сая төгрөгийн өртөг бүхий эм эргэлтийн сангийн барилга, Эрдэнэ суманд 25.0 сая төгрөгийн өртөг бүхий цаг уурын станц, Хатанбулаг суманд 20.0 сая төгрөгөөр иргэдэд үйлчлэх төвийн дэргэд гал тогооны барилгыг тус тус барьсан;
- Дорнод аймгийн Баян-Уул сум 12.5 сая төгрөг, Цагаан-Овоо сум 3.2 сая төгрөгийг түймэр унтраах үеийн шатахуун болон хоол хүнсний зардалд, Матад сум мал эмнэлэгийн болон хогны машины засварт 6.7 сая, ТББ-д дэмжлэг 7.9 сая төгрөг, нийтийн биеийн тамир хөгжүүлэхэд 4.3 сая төгрөг, боловсролыг дэмжихэд 2.2 сая төгрөг зарцуулсан;
- Завхан аймгийн 14 суманд мотоцикл худалдан авах, багийн эмч нарт хувцас нийлүүлэхэд 38.8 сая төгрөг, аймгийн засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны тайлан хэвлүүлэхэд 43.5 сая төгрөг зарцуулсан;
- Өвөрхангай аймгийн Уянга сум хог зайлуулалтад 30.0 сая төгрөг, Хархорин, Төгрөг сумд залуучуудыг дэмжих жилд 5.0 сая төгрөг, Хужирт сум цагдаагийн цахим торгуулийн машин авахад 4.1 сая төгрөг, Зүүнбаян-Улаан сум 3.0 сая төгрөгөөр ном хэвлүүлсэн зэрэг нийтдээ 14 төсөл арга хэмжээнд 79.1 сая төгрөгийг зарцуулсан;
- Өмнөговь аймгийн ОНХС-аас сүү тараг хөтөлбөрт 100.6 сая, автомашин авахад 29.9 сая, жудо бөхийн дэвжээ худалдан авахад 15.5 сая, малчдад мөнгөн урамшуулал олгоход 87.7 сая, эмч мэргэжилтний мэдлэг ур чадвар дээшлүүлэхэд 33.6 сая зэрэг нийт 564.0 сая төгрөгийг, Цогт-Овоо сум тохижилтын ажилд 9.8 сая төгрөг, зураг төсөв боловсруулах ажилд 2.5 сая төгрөг, Хүрмэн сум уралдааны шагналд 2.0 сая төгрөг, Гурвантэс сум засварын ажилд 11.2 сая төгрөг, Номгон сум сэтгүүл худалдан авахад 8.3 сая төгрөг, Гурвантэс сум гудамж талбайн гэрэлтүүлгийн урсгал зардалд 4.9 төгрөг тус тус зарцуулсан;
- Төв аймгийн Баян сум иргэнд төлөх газрын төлбөр 12.0 сая төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн, Эрдэнэ сум 19.8 сая төгрөгөөр сумын өвс, тэжээлийн фонд бүрдүүлсэн;
- Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын замын ажилд санхүүгийн дэмжлэг 100.0 сая төгрөг, сумын ЗДТГ-ын засварт 8.0 сая төгрөг, Мандал суманд барилгын дээвэр засварт 59.1 сая төгрөг, Алтанбулаг, Баруунбүрэн, Сайхан, Сүхбаатар сумд нохой устгах ажилд 28.1 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон, Алтанбулаг сум жишиг гудамж барихаар батлагдсан 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын зориулалтыг өөрчилж, урсгал засвар, тохижилтын ажилд зарцуулсан;
- Нийслэлийн СХД, ХУД, Чингэлтэй, Налайх, Багануур дүүрэг 5,136.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээнд 1,084.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон;
- Орхон аймгийн ОНХС-аас Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Даваат багийн сургуулийн барилгын ажилд 1,196.2 сая төгрөгийг олгосон, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын зураг төсвийн 11 ажилд 246.9 сая төгрөг, Баян-Өндөр сумын ОНХС-аас орц засварын 13 ажилд 179.3 сая төгрөг олгосон;
- Увс аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээс Дулааны 2-р станцад 150.0 сая, Цагаанхайрхан, Өлгий сумд гэржүүлэх төсөлд 15.0 сая, Баруунтуруун сум түлшинд 2.8 сая, Малчин сум тээврийн зардал, ажлын хөлсөнд 3.0 сая, ОНХС-ийн эх үүсвэрээс бэлтгэсэн өвс, тэжээл борлуулсны орлого 10.0 сая төгрөгийг иргэдэд цалин болгон олгосон.

Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулах төсвийн хувь хэмжээг зааглаагүй, хөтөлбөр, төсөл арга хэмжээний нэршлийг тодорхой тусгаагүйгээс сангийн хөрөнгийг хөтөлбөр, төсөл арга хэмжээ нэрээр зориулалт бусаар зарцуулан, урсгал зардлуудыг санхүүжүүлж тус сангийн үр нөлөөг бууруулах, үр ашиггүй зардал гарах нөхцлийг бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар



зүйлийн 60.3.1⁶⁵, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.3⁶⁶, 4.4⁶⁷ дэх заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Архангай аймгийн Төвшрүүлэх сум “Хог хөтөлбөр” арга хэмжээний хүрээнд 2.5 сая төгрөг, Өгийнуур сум “Хог хаягдлын менежментийг сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд 8.0 сая төгрөг;
- Говьсүмбэр аймагт хөтөлбөр нэрээр аймгийн нэгдсэн эмнэлэгт анализатор худалдан авахад 40.0 сая, Боржигин чуулгад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 19.9 сая, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт тоног төхөөрөмж худалдан авахад 4.8 сая, цагдаагийн хэлтэст тоног төхөөрөмж худалдан авахад 26.2 сая, хөдөөгийн багуудын тохижилтын ажилд 30.0 сая төгрөг;
- Булган аймагт хөтөлбөр болон дэд хөтөлбөрийн хүрээнд семинарын зардал, томилолт, сургаач багшийн цалин, олон нийтийн цагдаагийн цалин, нийтийн цэвэрлэгээ, нохой устгал зэрэгт нийт 293.3 сая төгрөг;
- Хөвсгөл аймаг “Аялал жуулчлал-ажилтай орлоготой Хөвсгөл” хөтөлбөрийн хүрээнд 15.2 сая төгрөг, “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 12.8 сая төгрөг, “Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр”-ийн хүрээнд 11.0 сая төгрөг, “Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 85.7 сая төгрөг;
- Увс аймагт “Албан бус боловсрол” хөтөлбөрийн хүрээнд 10.0 сая, “Эрүүл мэнд хөтөлбөр”-ийн хүрээнд 15.0 сая, “Спортын дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 30.0 сая, “Боловсрол хөтөлбөр”-ийн хүрээнд 60.0 сая, “Улаангом-330 төсөл”-ийн хүрээнд 5.0 сая төгрөгийг тус тус урсгал зардалд зарцуулсан байна.

Түүнчлэн зарим аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгөөр ойн арга хэмжээ тэмдэглэж, баяр наадмын зардлыг жишиг хэмжээнээс хэтрүүлэн санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1⁶⁸, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын 1⁶⁹ дэх заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Булган аймгийн 12 сум баяр наадмын зардлыг 71.9 сая төгрөгөөр, аймаг 40.0 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн;
- Сэлэнгэ аймаг баяр наадмын зардлыг 40.0 сая төгрөгөөр, Цагааннуур сум 2.9 сая төгрөгөөр, Дархан-Уул аймаг баяр наадмын зардлыг 19.8 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн;
- Завхан аймаг баяр наадмын зардлыг 70.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн, Богд Очирваань уулыг тахих үйл ажиллагаанд 40.0 сая төгрөг, эрийн гурван наадмын иж бүрдэлд 79.2 сая төгрөг тус тус зарцуулсан;
- Өмнөговь аймаг баяр наадмын зардлыг 215.0 сая төгрөгөөр, Мандал-Овоо сум 1.5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн, аймгийн гэгээрлийн хэлтсийн 85 жил, боловсрол мэргэжил арга зүйн байгууллага үүссэний 70 жил, багш нарын баярын 50 жилийн ойн арга хэмжээний зардалд 22.7 сая төгрөг тус тус зарцуулсан;
- Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум 90 жилийн ойн арга хэмжээнд 13.9 сая төгрөг зарцуулсан;
- Увс аймаг баяр наадмын зардлыг 20.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн, Сагил, Тариалан сумд ойн зардлын өр төлөхөд 11.9 сая, Завхан сум начинь алдар тэмдэглэхэд 1.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд зарцуулсан 4,063.2 сая төгрөгийн зөрчил гаргасныг илрүүлж 203.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 3,023.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага, 835.7 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

⁶⁵ Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ

⁶⁶ Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх

⁶⁷ Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх

⁶⁸ Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;

⁶⁹ Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож....



2.6 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавина” гэж эрх үүргийг хуульчилсан байна.

Гэтэл гүйцэтгэсэн ажлыг ашиглалтад оруулах комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээний хугацааг баримтлаагүй, ажлын даалгаврыг өөрчилсөн, захиалагчийн хяналт тавиагүй, захиалагчийн хяналт тавьсан тайлан, акт үйлдээгүй зөрчил нийтлэг байдлаар аудитын явцад илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3⁷⁰, 16 дугаар зүйлийн 16.5.2⁷¹, 41 дүгээр зүйлийн 41.2.3⁷², Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоол “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах дүрэм”-ийн 4.12⁷³, 4.13⁷⁴, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.25⁷⁵ дахь заалтуудыг баримталж, эрх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйг харуулж байна. Тухайлбал:

- Архангай аймгийн Хангай сумын 112.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шороон хучилттай авто замын ажлын гүйцэтгэгч Зургаадай зам ХХК гэрээт хугацаанд ажлыг гүйцэтгээгүй, ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Өндөр-Улаан сумын 46.9 сая төгрөгийн худаг гаргах ажил, Өгийнуур сумын 49.5 сая төгрөгийн тохижилтын ажилд захиалагчийн хяналт хийгдээгүй, Хайрхан сумын 54.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дулааны шугамын ажил, Эрдэнэбулган сумын 3, 7-р багийн 174.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга угсралтын ажилд мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгээгүй;
- Баянхонгор аймгийн Баянбулаг суманд халуун усны барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр 78.6 сая төгрөгийн гэрээг 2013 онд “Элит харш” ХХК-тай байгуулсан боловч тус компани гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, захиалагчийн хяналт тавиагүй, Баян-Өндөр суманд жи-мобайлын барилгын ажлыг гүйцэтгэгч “Ас холдинг” ХХК 55.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч барилгын хаяавч дутуу хийгдсэн, цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын гүйцэтгэгч “Гичгэнэ хяр” ХХК 52.1 сая төгрөгийн санхүүжилт авч 2015 онд ажлаа хүлээлгэн өгөх ёстой одоо хүртэл ажлаа дуусгаж хүлээлгэж өгөөгүй;
- Говь-Алтай аймгийн хэмжээнд 312.9 сая төгрөгийн 29 төсөл, арга хэмжээнд захиалагч, 659.2 сая төгрөгийн 38 төсөл, арга хэмжээнд хяналтын хороо тус тус хяналт тавиагүй;
- Сэлэнгэ аймгийн Түшиг сум 30.0 сая төгрөгийн өртөгтэй гэрэлтүүлэг, засвар үйлчилгээний ажил, Сайхан сум 79.9 сая төгрөгийн хөл бөмбөгийн талбай, 30.0 сая төгрөгийн гудамжны гэрэлтүүлгийн ажил, Мандал сум 79.5 сая төгрөгийн зам засах ажил, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,096.8 сая төгрөгийн өртөг бүхий 22 ажилд зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн тайлан, тэмдэглэл, дүгнэлтийг хавсаргаагүй, Ерөө суманд баригдсан 114.1 сая төгрөгийн өртөгтэй хөл бөмбөгийн талбай, Түшиг суманд баригдсан 50.0 сая төгрөгийн өртөг бүхий үерийн усны далан, Сүхбаатар сумын 107.0 сая төгрөгийн өртөгтэй байр, дээврийн засвар, Мандал сумын 61.4 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай, 63.7 сая төгрөгийн камержуулалтын ажлууд гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй бөгөөд гэрээнд хугацаа сунгасан нэмэлт өөрчлөлт хийгээгүй;
- Төв аймгийн Зуунмод сумын 75.7 сая төгрөгийн гэрэлтүүлгийн ажлыг Хас барс ХХК гүйцэтгэж комиссын актаар хүлээж авсан ч нийт гэрлийн 58 хувь буюу 332 гэрэл асахгүй, Баян сумын дунд

⁷⁰ Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны ИТХ, ЗГ, УИХ-ын өмнө бүрэн хариуцна

⁷¹ батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;

⁷² төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁷³ Комисс нь дараахь эрх, үүрэгтэй

⁷⁴ Захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, гүйцэтгэгч нь дараахь эрх үүрэгтэй

⁷⁵ Барилга, байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.



сургуулийн барилгын дээврийн засварын ажилд 2 гэрээ байгуулан 39.8 сая төгрөгийн санхүүжилтийг давхардуулан олгосон, Борнуур сумын “Эко орчин эрүүл амьдрал” ТББ-д ажил гүйцэтгэх гэрээгээр 26.5 сая төгрөг шилжүүлсэн;

- Завхан аймгийн 58.4 сая төгрөгийн инженерийн хийцтэй худаг гаргах ажил гэрээний хугацаанд хэрэгжээгүй;
- Өвөрхангай аймгийн Бүрд сумын сургуулийн спорт заалны засварын 57.9 сая төгрөгийн ажил агааржуулалт хийгдээгүйгээс ханын шохой хууларсан;
- Дорноговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа спорт цогцолбор барих 758.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгч “СНТ групп” ХХК-д гэрээний үнийн дүнгээс 33.9 сая төгрөг илүү шилжүүлсэн;
- Дундговь аймгийн Өлзийт суманд нийт 48.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй инженерийн хийцтэй худаг гаргах ажлын гүйцэтгэгч “Экогео” ХХК, “Цахиурт баян” ХХК-уудад санхүүжилтийг бүрэн олгосон боловч гэрээний хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгээгүй;
- Завхан аймгийн Сонгино сум тоног төхөөрөмж худалдан авах 55.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон ч ажил хийгдээгүй.

Зураг 3. Говьсүмбэр аймгийн Баянтал сумын уурын зуухны барилга



Эх сурвалж: Говьсүмбэр аймаг дахь төрийн аудитын газрын орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан

Говьсүмбэр аймгийн Баянтал суманд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн уурын зуухны барилгын их засварын ажлыг 2014.12.22-2015.09.01-ний хооронд 628.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Термокалор” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гэрээний хугацааг сунгаж 2016.05.25-нд ашиглалтад хүлээн авсан, тус ажлын зураг төсвийг 2014 онд “ДТУА” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн боловч “Термокалор” ХХК-нд зураг төсвийн үнэ 5.0 сая төгрөгийг давхардуулан олгосон байна.

Мөн тус уурын зуухны ажлыг төлөвлөхдөө сумын хүн амын тоо, нягтрал, орон сууцны хэрэгцээ, хэрэглэгчийн суурь судалгаа, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг үндэслэлтэй тооцоолоогүйгээс одоогийн нөхцөл байдалд ашиглахад хүчин чадал хэд дахин өндөр, ашиглалтын зардал их шаардагдаж ашиглах боломжгүй байсан тул 2016 оны ОНХС-ын хөрөнгөөс хуучин уурын зуухыг засварлахад 40.0 сая төгрөг зарцуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлсэн 14,995.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй, дутуу болон чанаргүй хийсэн, санхүүжилт авсан боловч ажлаа гүйцэтгээгүй, захиалагчийн хяналт тавиагүй зэрэг зөрчил илэрсэнд 430.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8,394.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 6,170.2 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Хэдийгээр ОНХС-ийн хөрөнгийг хууль, журам зөрчиж зарцуулж байгаа боловч Архангай, Дундговь зэрэг аймагт иргэдийн тогтвор суурьшилтай амьдрал, аж байдалд эерэг нөлөө үзүүлэх үр дүнтэй хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна. Тухайлбал:

Зураг 4. Дундговь аймгийн 644.7 сая төгрөгийн өртөгтэй “Өвлийн нарлаг хүлэмж”

Зураг 5. Архангай аймгийн Цэнхэр сумын 48.9 сая төгрөгийн өртөгтэй “Өвсний фондны хашаа”



Эх сурвалж: Дундговь аймаг дахь төрийн аудитын газрын
орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн
зарцуулалтад хийсэн аудитын тайлан



Эх сурвалж: Архангай аймаг дахь төрийн аудитын газрын
орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн
зарцуулалтад хийсэн аудитын тайлан

2.7 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу бүртгэл тайланд тусгаагүй байна

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг санхүүгийн бүртгэл тайланд тусгахгүй орхигдуулдаг зөрчил өмнөх онуудтай харьцуулахад энэ онд багассан боловч зарим аймгийн холбогдох албан тушаалтан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁷⁶, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁷⁷, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6⁷⁸ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг давтан гаргасан байна. Тухайлбал:

- Архангай аймгийн Булган сумын ЗДТГ 19.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хүндэтгэлийн хаалга барих ажил, 18.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гэрэлтүүлгийн ажлыг бүртгэлд тусгаагүй;
- Баян-Өлгий аймгийн Ногооннуур сум нь бөхийн дэвжээ, худгийн засвар, мотоцикл зэрэг 24.5 сая төгрөгийн хөрөнгийг, Дэлүүн сум 20.7 сая төгрөгийн трансформаторыг тус тус бүртгэлд тусгаагүй;
- Баянхонгор аймаг “Гурван бүс цогцолбор”-т явган зам, авто машины зогсоол барих 80.0 сая, Баянхонгор сумын 3-р багт инженерийн шугам сүлжээнд холбох 135.0 сая, аймгийн төвийн гэр хорооллын авто замын 3,706.8 сая, цэвэр усны байгууламжийн хяналтын камер 28.6 сая, Жинст сум 46.0 сая төгрөгийн өртөг бүхий багийн мэдээллийн төвийг тус тус бүртгэлд тусгаагүй;
- Булган аймгийн Баян-Агт сумын “Сургуулийн нэг ангийн тохижилт”-ын 19.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг данс бүртгэлд тусгаагүй;
- Говь-Алтай Алтай сумын 60.0 сая төгрөгийн өртөгтэй сумын ерөнхий хөгжлийн төлөвлөгөө, Чандмань сумын 46.2 сая төгрөгийн жи-мобайлын дэд бүтцийн сүлжээг данс бүртгэлд тусгаагүй;
- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3 дугаар багийн 5-р байрны 60.0 сая төгрөгийн их засварын ажил, 3-р байрны шугам сүлжээг шинэчлэх 60.0 сая төгрөгийн засварын ажил, Сүмбэр суманд цахилгаан татах 50.8 сая төгрөгийн ажил, 1-р байрны шугам, сүлжээг шинэчлэх 60.0 сая төгрөгийн ажил, Шивээговь суманд хийгдсэн 116.8 сая төгрөгийн 7 хөрөнгө оруулалтын ажлыг тус тус данс бүртгэлд тусгаагүй;
- Дорноговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 192.6 сая төгрөгийн өртөг бүхий авто зам, Замын-Үүд сум 371.1 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгө, Сайншанд сумын 2 дугаар багийн ЦДАШ, дэд станц барих 247.2 сая төгрөгийн ажлыг тус тус данс бүртгэлд тусгаагүй, Алтанширээ сумын 36.3 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгт хүрээлэн тохижуулах ажил, 21.4 сая төгрөгийн өртөг бүхий камержуулах ажлуудыг данс бүртгэлд хөрөнгө тус бүрээр тусгаагүй;
- Дорнод аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн 355.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтыг хүлээн авах эзэн тодорхойгүйгээс орлогоор хүлээн зөвшөөрч, капиталжуулаагүй;
- Өвөрхангай аймгийн Богд сум 29.7 сая төгрөгийн өртөгтэй төвийн 7 дугаар багийн 1,2,3 дугаар хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах ажлыг данс бүртгэлд тусгаагүй;
- Өмнөговь аймгийн Хүрмэн сум 73.4 сая төгрөгийн өртөгтэй агаарын шугам, гудамжны гэрэлтүүлгийн өргөтгөлийн ажлыг бүртгэлд тусгаагүй;

⁷⁶ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ...

⁷⁷ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

⁷⁸ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ



- Ховд аймгийн Прогресс сургуулийн 116.2 сая төгрөгийн өртөгтэй спортын талбай байгуулах ажил, 70.0 сая төгрөгийн өртөгтэй хүүхдийн паркын засвар, ногоон байгууламж, 48.6 сая төгрөгийн өртөгтэй бүсийн оношлогоо эмчилгээний төвийн зам талбайн өргөтгөл, 7 суманд шилэн кабель оруулсан 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудыг тус тус данс бүртгэлд тусгаагүй;
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 106.0 сая төгрөгийн усан бассейны дулааны шугамын ажил, Сүхбаатар сумын тоглоомын талбай байгуулах 25.0 сая төгрөгийн ажил, аймгийн ахмад, залуу гэр бүлийн ордонд худалдан авсан 30.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, ялтсан бойлер суурилуулах 88.1 сая төгрөгийн ажил, Алтанбулаг сумын сургуулийн 62.7 сая төгрөгийн засвар зэрэг нийт 395.0 сая төгрөгийн өртөг бүхий 11 хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгаагүй.


Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгээгүй 7,708.7 сая төгрөгийн зөрчилтэй холбогдуулан 9.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 7,260.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 438.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлээ.

ОНХС-ийн хөрөнгийн 2016 оны зарцуулалтад хийсэн аудитаар нийт 37,995.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 695.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 24,073.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 13,226.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэв. /Хавсралт 4/

Нийцлийн аудитын газраас ОНХС-ийн хөрөнгийн 2013 оны зарцуулалтад хийсэн аудитаар 46.2 тэрбум, 2014 оны зарцуулалтад хийсэн аудитаар 87.2 тэрбум, 2015 оны зарцуулалтад хийсэн аудитаар 47.9 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлж холбогдох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн удирдлагад танилцуулж шийдвэрлүүлж байсан.

ОНХС-ийн 2013-2016 оны хөрөнгийн эх үүсвэр, аудитаар илэрсэн зөрчлийг зургаар үзүүлэв.

Зураг 6. ОНХС-ийн эх үүсвэр, илэрсэн зөрчлийн харьцаа (тэрбум төгрөг)




Эх сурвалж: УАГ-ын орон нутгийн хөгжлийн сангийн 2013-2015 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан, орон нутаг дахь төрийн аудитын газрын орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан

Илэрсэн зөрчлийг ангиллаар нь авч үзвэл төсөвт өртгөөс илүү санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын ажлыг дутуу, чанаргүй гүйцэтгэх, иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг баталж хэрэгжүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах чиг үүрэгт нийцээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зөрчил буурсан бөгөөд зураг төсөвгүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, захиалагчийн хяналт тавиагүй зөрчил 2016 онд нэмэгдсэн байна.



ОНХС-ийн 2013-2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг зургаар үзүүлэв.

Зураг 7. Аудитаар илэрсэн зөрчил (тэрбум төгрөг)



Эх сурвалж: УАГ-ын орон нутгийн хөгжлийн сангийн 2013-2015 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан, орон нутаг дахь төрийн аудитын газрын орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан

Аудитаар өмнө илэрч байсан зөрчлүүд арилахгүй давтагдаж байгаа нь орон нутгийн удирдлагууд сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журам, зааврыг мөрдөхгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, дээд шатны удирдлагаас зөрчил гаргасан албан тушаалтнуудтай хариуцлага тооцохгүй байгаатай холбоотой байна.



БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

3.1 ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон дотоод аудитын алба ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба тус тус хэрэгжүүлэхээр Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1⁷⁹, 9.2⁸⁰-оор тодорхойлж зохицуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁸¹ дэх заалт, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.2-т заасны дагуу Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хөвсгөл аймаг, Нийслэлийн зарим дүүргийн дотоод аудитын албанаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд хяналт шалгалт явуулсан, Дархан-Уул аймгийн зарим сумд, Төв, Хэнтий аймаг дээрх зааврын 9.1 дэх заалтын дагуу хяналт тавьсан байхад бусад орон нутгийн дотоод аудитын алба, хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд дээрх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын хүрээнд авсан санал асуулгаар “ОНХС-н санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтад иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа юу?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 36.6 хувь буюу 7963 иргэн “энэ талаар мэдэхгүй байна”, 20.1 хувь буюу 4365 иргэн “боломжгүй” гэдэг хариултыг өгсөн нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

3.2. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу хүргүүлж, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна

Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1, 10.2-т сум дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас болон бүтэн жилийн тайланг аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлэх, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар уг тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулахаар заасан байна.

Гэвч Дархан-Уул, Баян-Өлгий, Хэнтий аймгаас бусад аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч,

⁷⁹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана

⁸⁰ ОНХС-аас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ

⁸¹ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.



цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмжийн биелэлтийн талаар сумдын Засаг дарга, ОНХС хариуцсан ажилтан нарт үүрэг өгч ажиллаагүй нь ОНХС-ийн зааврын 10.1⁸², 10.2⁸³ дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл зэрэг аймаг дүн шинжилгээ хийгээгүй байна.

3.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг олон нийтэд хүргээгүй байна

Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 11.2.3⁸⁴-т ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаар Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд тогтмол мэдээлэх, 11.2.4⁸⁵-т аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн сангийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг тухай бүр системд оруулж бүртгэхээр тус тус заасан боловч орон нутагт дээрх заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Баян-Өлгий аймгийн нийт сумд ОНХС-ийн сарын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нийт дүнгээр мэдээлсэн, ажлын зураг төсөв, гүйцэтгэл, хүлээж авсан акт, тухайн төсөл, арга хэмжээтэй холбоотой ирүүлсэн санал, гомдол зэрэг мэдээллийг байршуулаагүй;
- Завхан аймагт иргэд интернетийн сүлжээ ашиглах боломж хязгаарлагдмал учир цахим хэлбэрийн мэдээллийг тэр бүр хүлээн авч чаддаагүй;
- Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг мэдээллийн самбарт тухай бүр байршуулаагүй;
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум цахим хуудсанд ИТХ-аар хэлэлцэн баталсан төсвийн тодотголын мэдээ буюу шинэчлэн батлагдсан ТАХ-ий жагсаалтыг байршуулаагүй;
- Увс аймгийн дийлэнх сумд ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр батлагдсан ажлын жагсаалтыг ЗДТГ-ын мэдээллийн самбарт байршуулсан боловч санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилээгүй;
- Хэнтий аймгийн 13 сум 39 төсөл, арга хэмжээний төндөрийн мэдээллийг мэдээллийн самбарт, 309 төсөл, арга хэмжээний зураг, гүйцэтгэл, актыг цахим хуудсанд тус тус байршуулаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг хаанаас авах талаарх иргэдийн мэдлэг дутмаг;
- Хөвсгөл аймгийн зарим сум төсөл, арга хэмжээний мэдээллийг цахим хуудсанд алдаа зөрчилтэй, дутуу мэдээлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлээгүй нь Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл⁸⁶-д орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангана, 68 дугаар зүйлийн 68.3-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитын хүрээнд иргэдээс авсан санал асуулгаар “ОНХС-ийн санхүүжилтээр ямар төсөл, арга хэмжээ танай хороо, суманд хэрэгжиж буй талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 53.4

⁸² Сум дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ний дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна.

⁸³ Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг сум дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 дугаар сарын 25-ний дотор хэлэлцүүлнэ.

⁸⁴ Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд тогтмол мэдээлэх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилж хийнэ.

⁸⁵ Аймаг, нийслэл, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн, сумын төрийн сангийн төлөөлөгч ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг тухай бүр системд оруулж бүртгэнэ.

⁸⁶ Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах



хувь буюу 11603 иргэн, “ОНХС-н санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг зарладаг уу?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 59.2 хувь буюу 12867 иргэн “мэдэхгүй” гэсэн хариултыг тус тус өгсөн нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ, санхүүжилтийн талаарх мэдээллийг зөвхөн мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулснаар хязгаарлаж байгаагаас иргэдэд хүрч чадаагүйг харуулж байна.

Иймд ОНХС-ийн талаар иргэдэд сурталчилах ажлыг эрчимжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

3.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг бусад хууль, тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна

ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх, санхүүжүүлэх, зарцуулалтад хяналт тавих, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, тайлагнах үйл ажиллагааг зохицуулахаар Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын 2.3.9⁸⁷-т заасны дагуу Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгэгдээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл⁸⁸, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7⁸⁹-д аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүргүүдийг тодорхойлсон.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.3-т “*нийслэлийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх*” чиг үүргийг нийслэл өөрийн төсвөөр бие даан хэрэгжүүлэхээр заасан байхад “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.3.6-д уг чиг үүргийг дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэгт хамааруулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1⁹⁰ дэх заалттай зөрчилдөж байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4, 58.2.4, 58.3.2, 58.4.2-т аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах хуулийн зохицуулалттай байхад “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.6-д “*ОНХС-ийн хөрөнгийг буцалтгүй тусламж, дэмжлэгэд зарцуулахгүй байх*” хэмээн заасан нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11-т “*Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй*” гэж хуульчилсан байхад “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 1.1-д “*...нутгийн засаг захиргаа иргэд, олон нийтийн оролцоотой, хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах...*”, 4.2-т “*тухайн орон нутгийн иргэдийн саналыг*

⁸⁷ Эрх бүхий этгээд нь шийдвэрийг баталснаас хойш ажлын арван өдрийн дотор хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ.

⁸⁸ Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг

⁸⁹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүд

⁹⁰ орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.



авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх”, 4.4-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” гэсэн заалт нь тодруулбал төсөл арга хэмжээг төлөвлөхөд баримтлах зарчимтай уялдахгүй, зөрчилдөх нөхцлийг үүсгэсэн байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.4-т “орон нутагт олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар сонгон шалгаруулалт хийхийг түлхүү дэмжинэ” хэмээн заажээ.

Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд тус журмын 2.1-д “Сум дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулахдаа захиалагч нь хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хороо байгуулна” гэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1⁹¹ дэх заалттай зөрчилдөж байна.

Дээрх журмын 2.2-т төсөл, арга хэмжээ нь ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байхаар заасан бөгөөд сум, орон нутагт ихэнхдээ 10.0-40.0 сая төгрөгийн өртөгтэй бага хэмжээний барилгын засварын ажлууд хийгддэг нь дээрх хууль болон журмын заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байна.

Иймд “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг бусад хууль, тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна.

3.5 Өмнөх аудитаар өгөгдсөн актын биелэлт 86.4 хувь, албан шаардлагын биелэлт 91.1 хувь, зөвлөмжийн биелэлт 75.5 хувьтай байна


ОНХС-ийн хөрөнгийн 2015 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар нийт 47,869.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 525.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 32,612.6 сая төгрөгийн албан шаардлага, 14,731.8 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг зургаар үзүүлэв.

⁹¹ Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.



Зураг 8. Өмнөх аудитаар тавигдсан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (сая төгрөг)



Эх сурвалж: ҮАГ-ын орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан, орон нутаг дахь төрийн аудитын газрын орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайлан

Орон нутгийн удирдлагууд өмнөх аудитаар илэрсэн зөрчилд тавьсан актын 13.6 хувийг, өгсөн албан шаардлагын 8.9 хувийг, зөвлөмжийн 24.5 хувийг тус тус биелүүлээгүй байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй аймгуудыг дурьдвал:

- Архангай аймагт 4.7 сая төгрөгийн төлбөрийн акт биелэгдээгүй тул биелэлтийг хангуулахаар хуулийн байгууллагад шилжүүлсэн;
- Завхан аймагт 7.0 сая төгрөгийн төлбөрийн акт биелэгдээгүй бөгөөд 5.9 сая төгрөгийн акт хуулийн байгууллагад шилжсэн, орон нутгийн удирдлага солигдсонтой холбогдуулан албан шаардлага бүрэн хэрэгжээгүй;
- Булган аймагт 7.6 сая, Говь-Алтай аймагт 39.5 сая, Дорноговь аймагт 3.4 сая, Хөвсгөл аймагт 5.1 сая, Сүхбаатар аймагт 3.9 сая төгрөгийн төлбөрийн акт төлөгдөөгүй;
- Дорноговь аймагт хөрөнгийг бүртгэх тухай 432.8 сая төгрөгийн 2 албан шаардлага гүйцэтгээч байгууллагыг шүүхэд шилжүүлсэнээс шалтгаалан биелэгдээгүй;
- Баянхонгор аймагт 22.0 сая төгрөгийн албан шаардлага биелэгдээгүй байсанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба төлбөрийн акт тогтоосон;
- Албан шаардлагыг Булган аймаг 84 хувь, Дорноговь аймаг 40 хувь, Хөвсгөл аймаг 50 хувь, зөвлөмжийг Баянхонгор аймаг 76.4 хувь, Дорноговь аймаг 67 хувь, Дорнод аймаг 73 хувь, Хөвсгөл аймаг 61 хувь, Говьсүмбэр аймаг 40 хувь, Ховд, Увс аймгууд 50 хувь тус тус хэрэгжүүлсэн;
- Сэлэнгэ аймаг 14.4 сая төгрөгийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тавьсан;
- Хөвсгөл аймагт зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс үүдэн өмнөх онуудаас зөрчил дутагдал нэмэгдсэн, зөвлөмжийг биелүүлээгүй төрийн албан хаагчдад Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т зааснаар хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгийн 2015 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулаагүй, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг энэ онд давтан гаргасан, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хариуцлага тооцох” зөвлөмж өгөгдсөн ч хэрэгжилт хангалтгүйгээс аймаг, нийслэлийн удирдлага акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, өмнөх онд илэрч байсан зөрчлүүд давтан гарсан байна.



Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.06.19 № 13-1/3730
танай 2017.06.08-ны № 2/1079 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б. АЛТАНЗУЛ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

“Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Та бүхний аудитаар илрүүлсэн асуудлууд, гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хүлээн авах саналтай байгаа бөгөөд дараах тайлбар, саналыг хүргүүлж байна.

Үүнд:

Тайлбар 1-ийг
үзнэ үү.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр батлагдаж, хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 ба 60.6 дахь хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх тул ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос “Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэг тооцох аргачлал”-ыг боловсронгуй болгож, хуваарилалтын зохистой арга хэлбэрийг эрэлхийлэх болно.

Тайлбар 2-ыг
үзнэ үү.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Тогтвортой амьжиргаа-3 төсөл”-ийн хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд үнэлгээ хийн, сайн хэрэгжилттэй сумдад урамшуулал олгох тогтолцоог нэвтрүүлэхийн зэрэгцээ хангалтгүй үнэлгээтэй сумдын орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүний дагуу орон нутгийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах “Аймгийн чадавхыг бэхжүүлэх баг”-ийг байгуулан, сургалтанд хамруулж эхэлсэн ба тодорхой үр дүн гарна гэж үзэж байна. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, холбогдох журам, зааврыг шинэчлэх чиглэлээр зөвлөх, мэргэжилтнүүдийн баг ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т өөрчлөлт оруулах юм.

Тайлбар 3-ыг
үзнэ үү.

Аудитаар өмнө илэрч байсан зөрчлүүд арилахгүй давтагдаж байгаа нь дээд шатны удирдлагаас зөрчил гаргасан орон нутгийн удирдлагууд, албан тушаалтнуудтай хариуцлага тооцохгүй байгаагаар холбоотой тул өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтсан аймаг, нийслэлийн Засаг даргын нэрийг зөвлөмжид дурдах нь зүйтэй.

Хүндэтгэсэн,

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Б.НЯМАА

6604



Саналд өгөх тайлбар:

Тайлбар 1. Саналыг хүлээн авах боломжгүй.

Тайлбар 2. Саналыг хүлээн авах боломжгүй.

Тайлбар 3. Саналыг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг хийлээ.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль тогтоомжийн дагуу төлөвлөсөн боловч ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахад ашиглах хөгжлийн индексийг шинэчлэн зарлаагүй байна.
2. Аймаг, нийслэлийн ОНХС нь улсын төсвөөс олгох 2 төрлийн шилжүүлгийн 33 болон 50-иас доошгүй хувийг ашигт малтмал ашигласан болон тусгай зөвшөөрөл олгогдсон талбайд байрших тухайн сум, дүүргийн ОНХС-д олгох Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5, 60.6 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй байна.
3. Аймаг, нийслэлийн удирдлага ОНХНС болон улсын төсвөөс олгох шилжүүлгээс бусад ОНХС-ийн хуульд заасан эх үүсвэрийг төлөвлөх, бүрдүүлэх талаар санаачилгагүй ажилласан байна.
4. Аймаг, нийслэлийн ОНХС-д ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгийг бүрэн олгосон боловч санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгоогүй нь төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлсөн байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэлэлцэх баг, хорооны ИНХ-д оролцох иргэдийн оролцоо хангалтгүй, ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг олон нийтэд хүргэж чадаагүй байна.
6. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй, мөн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлж байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах эрсдэлийг дагуулж байна.
7. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарим үнэлгээний хороо, ажлын хэсгүүд холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.
8. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгээгүй зэрэг нь ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна.
9. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй нь хөрөнгө эзэнгүйдэх, цаашлаад үрэгдэх эрсдэлийг дагуулж байна.
10. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын дагуу хүргүүлж, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.
11. Аймаг, нийслэлийн дотоод аудитын алба, Засаг даргын дэргэдэх хяналт, шалгалтын байгууллага, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
12. "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ыг Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл, 60 дугаар зүйлийн 60.11 дэх заалттай нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулаагүй, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг энэ онд давтан гаргасан, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хариуцлага тооцох; /Дэлгэрэнгүйг хавсралт 5-д үзүүлэв/
2. ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахад мөрдөх хөгжлийн индексийг тооцож, зарлуулах ажлыг зохион байгуулах;

Монгол Улсын Сангийн сайдад:

1. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5, 60.6 дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос ОНХС-д олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын хэрэгжилтийг хангуулах;
2. Аймаг, нийслэлийн холбогдох албан тушаалтнуудад ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийг бодитой, үндэслэл сайтай боловсруулах чадвар эзэмшүүлэх, дадлагажуулах ажлыг эрчимжүүлж хяналт тавих хөшүүрэг бий болгох;
3. Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл, 60 дугаар зүйлийн 60.11 дэх заалттай нийцүүлэн “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т өөрчлөлт оруулах.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлахдаа холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах;
2. ОНХС-ийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журам, зааврыг баримталж, сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг хууль журмын дагуу бүртгэл тайланд тусгах;
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянах хяналтын хороо, дотоод аудитыг ажиллуулах, захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, зөрчил гаргасан гүйцэтгэгчдэд хариуцлага тооцох;
4. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1, 9.4 дэх заалтын дагуу аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний үр дүнд хяналт тавих,
5. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1, 10.2, 10.3-т заасны дагуу ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг хүлээн авах, дүн шинжилгээ хийх, аймаг, нийслэлийн засаг дарга ажлын хэсгийг томилж ажиллуулах;



6. Төсвийн тухай хууль, ОНХС-ийн зарцуулалттай холбоотой заавар, журмыг иргэдэд таниулах, төсөв төлөвлөх, бүрдүүлэх хуваарилах тайлагнах, хянах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах;
7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтнүүдийн тухайн орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбарт шуурхай байршуулж, нийтэд тогтмол мэдээллэх, шинэчлэх ажлыг эрчимжүүлэх.



Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал



2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/121

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Сангийн сайд нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД 2016 ОНД ТӨВЛӨРҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР

(сая.төг)

№	Аймаг, нийслэл	Өмнөх оны үлдэгдэл	ОНХНС болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг	Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон эх үүсвэр	Хандив, тусламж болон бусад	Нийт эх үүсвэр
1	Архангай	362.1	3,179.9	-	237.5	-	3,779.5
2	Баян-Өлгий	127.4	3,260.1	-	-	152.6	3,540.1
3	Баянхонгор	433.5	4,737.8	-	-	1,328.6	6,499.9
4	Булган	991.6	3,550.5	-	74.2	-	4,616.3
5	Говь-Алтай	330.5	5,693.7	-	-	125.2	6,149.3
6	Говьсүмбэр	160.1	2,227.4	556.4	694.1	-	3,638.0
7	Дархан-Уул	812.9	3,295.3	-	-	-	4,108.2
8	Дорноговь	135.8	5,579.9	-	-	34.8	5,750.4
9	Дорнод	259.9	4,140.6	219.3	-	329.1	4,948.9
10	Дундговь	916.3	4,114.7	444.0	-	19.5	5,494.5
11	Завхан	611.9	4,185.8	330.0	213.4	656.3	5,997.4
12	Орхон	121.2	3,562.0	4,236.8	-	21.9	7,941.9
13	Өвөрхангай	220.4	3,444.4	-	-	68.6	3,733.4
14	Өмнөговь	1,206.9	21,515.0	-	8,776.6	12.7	31,511.3
15	Төв	463.4	6,300.9	-	-	61.0	6,825.3
16	Ховд	273.7	3,664.1	-	-	31.6	3,969.4
17	Хөвсгөл	133.3	3,395.6	462.2	113.5	-	4,104.6
18	Хэнтий	509.3	4,417.2	238.5	60.6	-	5,225.6
19	Сүхбаатар	35.7	7,681.2	233.6	970.1	898.8	9,819.3
20	Сэлэнгэ	443.0	4,887.3	-	-	7.5	5,337.8
21	Увс	373.5	3,040.6	265.8	-	66.5	3,746.4
22	Нийслэл	3,044.1	14,393.7	-	-	-	17,437.8
	НИЙТ ДҮН	11,966.4	120,267.7	6,986.6	11,140.0	3,814.6	154,175.3



**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨР**

(сая.төг)

№	Аймаг, нийслэл	ИТХ-аар батлагдсан		Бүрэн хэрэгжсэн		Үүнээс: Дутуу хэрэгжсэн		Огт хэрэгжээгүй	
		тоо	өртөг сая/төг	тоо	гэрээний дүн сая/төг	тоо	гэрээний дүн сая/төг	тоо	өртөг сая/төг
1	Архангай	197	4,234.5	145	3,011.7	15	513.1	37	709.9
2	Баян-Өлгий	240	3776.2	237	3704.6	-	-	3	37
3	Баянхонгор	332	6,500.5	266	4,917.1	26	1,052.7	40	530.7
4	Булган	247	4,683.0	199	3,439.8	18	584.7	30	493.3
5	Говь-Алтай	369	6,350.7	215	5,145.0	10	168.6	144	1,037.1
6	Говьсүмбэр	157	3635.1	127	2,689.50	23	306.3	7	639.30
7	Дархан-Уул	98	4108.2	69	3012.8	15	798.2	14	297.1
8	Дорноговь	124	5562	119	5497.1	3	200.1	2	40
9	Дорнод	225	5159.1	191	3446.5	5	131.4	29	403.3
10	Дундговь	229	5,529.5	181	4,735.1	4	108.8	44	587.0
11	Завхан	284	4900.5	154	3356.7	8	245.3	122	1132.3
12	Орхон	162	7,815	161	7,484	1	80	-	-
13	Өвөрхангай	226	3,894.3	194	3,542.4	15	164.0	17	148.9
14	Өмнөговь	248	31,495.0	202	15,454.0	15	10,746.0	31	4,159.0
15	Төв	274	6,847.5	193	4,163.7	13	958.8	68	1,323.8
16	Ховд	241	3,727.7	183	3,244.4	36	632.1	22	270.6
17	Хөвсгөл	306	4,928.9	256	3,461.1	19	887.2	31	402.0
18	Хэнтий	309	5,664.7	243	4,376.5	21	915.5	45	381.3
19	Сүхбаатар	203	9,229.1	173	7,473.8	3	44.8	27	1,150.6
20	Сэлэнгэ	202	5,331.2	184	4,447.2	9	529.0	9	399.7
21	Увс	260	3,985.3	227	3,553.0	-	-	33	332.4
22	Нийслэл	378	27,201.2	330	18,686.6	18	3,393.8	30	3,708.4
	Нийт дүн	5,311	164,559.1	4,249	118,842.3	277	22,460.3	785	18,183.8



Хавсралт 3

№	Аймаг, нийслэл	Төлөвлөсөн шинэ оны ажил	Худалдан авах ажиллагааны журам										Шууд худалдан авалт				
			Төндөр шалгаруулалтын онцгой журам					Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам		ОНО-той ХАА- ны журам							
			НТШ-ын журам		ХТШ	Харьцуулалтын арга		Гэрээ шууд байгуулах		тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/
тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/		
1	Архангай	154	2,905.7	8	876.3	-	-	52	1,257.0	65	452.6	-	-	-	-	29	319.8
2	Баян-Өлгий	166	1,581.8	6	270.6	-	-	20	508.9	140	801.9	-	-	-	-	-	-
3	Баянхонгор	226	2,865.1	10	751.4	-	-	20	599.9	193	1,459.2	-	-	-	-	3	54.6
4	Булган	223	4,324.2	11	1,477.7	1	72.3	40	912.3	66	684.1	10	134.1	15	91.4	80	863.1
5	Говь-Алтай	345	4,611.6	17	1,020.2	-	-	16	587.6	243	2,094.1	4	218.0	20	190.1	45	501.5
6	Говьсүмбэр	83	2,695.6	7	936.2	-	-	18	645.2	52	629.1	-	-	-	-	6	485.1
7	Дархан-Уул	65	3,621.6	25	2,852.1	-	-	11	420.7	29	348.8	-	-	-	-	-	-
8	Дорноговь	100	3,318.4	11	550.8	-	-	48	1,508.4	30	226.1	-	-	11	188.4	-	-
9	Дорнод	185	3,964.7	14	1,795.7	1	48	33	819.7	89	676.3	-	-	-	-	48	625.0
10	Дундговь	209	2,990.2	13	552.1	-	-	58	1,640.1	-	-	1	100.0	39	107.1	98	591.0
11	Завхан	243	5,048.7	16	2,268.2	3	974.3	24	439.5	200	1,360.3	-	-	-	-	-	-
12	Орхон	156	7,376.7	10	3,786.2	-	-	41	1,593.4	37	285.0	2	27.7	47	629.9	19	1,054.4
13	Өвөрхангай	211	3,549.8	19	1,853.4	5	119.5	55	717.5	106	568.0	-	-	-	-	26	291.4
14	Өмнөговь	225	31,040.4	39	21,382.5	-	-	75	3,336.1	111	1,017.6	-	-	19	319.8	59	4,191.7
15	Төв	176	4,552.0	15	1,535.8	-	-	39	1,891.8	122	1,124.4	-	-	-	-	-	-
16	Ховд	192	2,826.5	10	940.3	-	-	35	773.5	133	943.0	-	-	-	-	14	137.2
17	Хөвсгөл	231	3,443.8	13	1,507.4	6	211.1	75	1,452.7	148	741.7	-	-	-	-	16	150.5
18	Хэнтий	278	5,369.5	11	1,533.2	1	50	48	1,575.6	200	1,979.5	-	-	-	-	49	526.5
19	Сүхбаатар	114	3,897.1	6	692.5	-	-	13	514.8	68	1,718.4	-	-	-	-	27	971.5
20	Сэлэнгэ	148	4,213.2	8	916.6	-	-	69	2,580.3	48	305.9	1	55.0	5	76.3	17	237.9
21	Увс	182	1,995.4	-	-	-	-	10	322.0	108	817.7	-	-	-	-	64	855.6
22	Нийслэл	257	18,845.5	49	9,077.6	-	-	99	4,602.0	42	528.2	-	-	41	566.4	26	3,584.0
	Нийт	4,169	125,038	318	56,577	17	1,475	899	28,699	2,230	18,762	18	535	197	2,169	626	15,441



**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН АУДИТААР ИЛЭРСЭН
ЗӨРЧИЛ**

(сая.төг)

№	Аймаг, нийслэл	Нийт илэрсэн зөрч- лийн дүн	Зөрчлийн ангилал							
			Зориу- лалт бус	Иргэдийн саналаар дэмжиг- дээгүй	Худалда н авах ажилла- гааны журам зөрчсөн	Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн	Бүртгэл тайланд тусгаагүй	ТЭЗҮ, зураг төсөв батлаг- даагүй	Хэрэгж ээгүй, илүү санхүү жүүл- сэн	Захиалаг- чийн хяналт тавиагүй болон бусад
1	Архангай	1,136.5	1.8	7.1	228.3	211.1	41.9	73.2	77.4	495.7
2	Баян-Өлгий	505.3	247.2	170.7	-	9.0	64.6	-	13.8	-
3	Баянхонгор	4,605.7	44.8	88.2	54.5	251.5	4,107.9	15.0	1.8	42.0
4	Булган	938.4	113.4	575.1	-	13.0	57.7	68.7	32.2	78.3
5	Говь-Алтай	5,168.8	751.1	593.1	358.0	-	172.3	178.3	-	3,116.0
6	Говьсүмбэр	881.2	80.0	42.2	-	106.7	393.8	-	14.5	244.0
7	Дархан-Уул	151.0	44.8	-	-	106.2	-	-	-	-
8	Дорноговь	2,533.3	112.5	225.2	-	-	986.9	596.2	38.8	573.7
9	Дорнод	963.8	115.6	-	144.0	-	365.3	300.0	-	38.9
10	Дундговь	1,119.8	166.2	524.6	216.3	-	171.4	10.6	-	30.7
11	Завхан	1,074.0	518.8	34.8	7.0	223.9	4.0	20.0	224.1	41.4
12	Орхон	499.4	-	426.2	-	73.2	-	-	-	-
13	Өвөрхангай	729.5	79.1	16.3	-	531.6	29.7	-	42.3	30.5
14	Өмнөговь	2,529.2	808.7	-	244.8	-	91.5	91.8	26.5	1,265.9
15	Төв	425.6	38.8	-	-	28.5	322.5	-	35.8	-
16	Ховд	1,149.8	123.3	43.2	222.7	5.0	385.0	-	-	370.6
17	Хөвсгөл	1,822.9	14.0	140.5	-	1,321.5	-	335.7	-	11.2
18	Хэнтий	566.9	2.8	99.3	40.0	36.7	2.3	354.3	31.5	-
19	Сүхбаатар	310.7	42.8	46.8	76.6	12.8	83.5	-	25.0	23.2
20	Сэлэнгэ	2,397.2	288.8	798.5	339.2	14.4	395.0	241.2	9.5	310.6
21	Увс	854.0	468.7	179.7	109.0	10.0	33.4	-	6.5	46.7
22	Нийслэл	7,632.8	-	986.3	-	11.0	-	1,900.0	-	4,735.5
	Нийт	37,995.8	4,063.2	4,997.8	2,040.4	2,966.1	7,708.7	4,185.0	579.7	11,454.9



ӨМНӨХ АУДИТААР ТАВЬСАН АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ АЙМГУУД

№	Аймаг	Албан шаардлага (сая.төг)		
		Дүн	Биелэлт	Биелэлт хувь
1	Дорноговь	2,286.9	914.8	40 хувь
2	Ховд	224.6	146.7	65 хувь
3	Хөвсгөл	1,446.3	723.2	50 хувь

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ АЙМГУУД

№	Аймаг	Зөвлөмж /тоогоор/		
		Тоо	Биелэлт	Биелэлт хувь
1	Говьсүмбэр	30	12	40 хувь
2	Дорноговь	18	12	67 хувь
3	Ховд	2	1	50 хувь
4	Хөвсгөл	140	85	61 хувь
5	Увс	11	5.5	50 хувь

ӨМНӨХ АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ЭНЭ ОНЫ АУДИТААР НЭМЭГДСЭН АЙМГУУД

(сая.төг)

№	Аймгийн нэр	2015 он	2016 он	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
1	Архангай	528.5	1,136.5	608.0	115 хувь
2	Баянхонгор	2,268.1	4,605.7	2,337.6	103 хувь
3	Дархан-Уул	13.7	151.0	137.3	1002 хувь
4	Ховд	359.2	1,149.8	790.6	220 хувь
5	Хэнтий	121.4	566.9	445.5	367 хувь
6	Увс	204.4	854.0	649.6	318 хувь

